

**“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2025 оны 03 дугаар сарын 29-ний өдөр

№ Т-25/01

Улаанбаатар хот

“ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал (цаашид “ХЭЭХ”) 2025 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн 12:00 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Ерөнхий Сайд Амарын Гудамж-2 тоот хаягт Галлериа Улаанбаатар төв (Galleria Ulaanbaatar Center)-ийн 3 давхар, Juulchin Grand Ballroom танхимд зохион байгуулагдав.

ХЭЭХ-д оролцсон албан тушаалтнууд:

- ХЭЭХ-ын дарга: Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн дарга О.Болдбаатар,
- Компанийн ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирал Ц.Ууганбаяр,
- Компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүн, ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны дарга Ж.Жаргалсүрэн,
- Компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүн, ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны гишүүн, ТУЗ-ийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх хорооны дарга С.Боргил,
- Компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүн, ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хорооны дарга бөгөөд Цалин урамшууллын хорооны дарга С.Нэргүй,
- Компанийн ТУЗ-ийн гишүүн, ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хорооны гишүүн С.Энх-Амгалан,
- ХЭЭХ-ын Тооллогын комиссын дарга: “Өмгөөллийн ЭмДиЭс энд Хаанлекс” ХХН-ийн партнер, өмгөөлөгч С.Батбуян,
- ХЭЭХ зохион байгуулах комиссын дарга, Компанийн Санхүү, үйл ажиллагааны газрын захирал М.Түвшинжаргал,
- Компанийн ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга Б.Оюунболд нар оролцож, ХЭЭХ-ыг хурал зохион байгуулах комиссын дарга М.Түвшинжаргал хөтлөн явуулав.

ХЭЭХ-ын ирц: Нийт саналын эрх бүхий хувьцааны **81.64%**

ХЭЭХ зохион байгуулах комиссын дарга М.Түвшинжаргал:

Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигчид та бүхэндээ энэ өдрийн мэнд хүргэе. “ЛэндМН ББСБ” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал эхлэхэд бэлэн болсон байна.

Энэхүү хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож байгаа хүмүүсийг танилцуулъя.

“ЛэндМН ББСБ” ХК-ийн ТУЗ-ийн дарга, Хувьцаа эзэмшигчдийн хурлын дарга О.Болдбаатар; “ЛэндМН ББСБ” ХК-ийн ТУЗ-ийн гишүүн Гүйцэтгэх захирал Ц.Ууганбаяр; “ЛэндМН ББСБ” ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүн, ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны дарга Ж.Жаргалсүрэн;

“ЛэндМН ББСБ” ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүн, ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны дарга С.Боргил;

“ЛэндМН ББСБ” ХК-ийн ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хорооны дарга бөгөөд Цалин урамшууллын хорооны дарга С.Нэргүй;

“ЛэндМН ББСБ” ХК-ийн ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хорооны гишүүн С.Энх-Амгалан;

Тооллогын комиссын дарга “Өмгөөллийн ЭмДиЭс энд ХаанЛекс ХХН”-ийн Партнер С.Батбуян; “ЛэндМН ББСБ” ХК-ийн ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга Б.Оюунболд;

“ЛэндМН ББСБ” ХК-ийн Санхүү, үйл ажиллагааны газрын захирал, Хурал зохион байгуулах комиссын дарга М.Түвшинжаргал миний бие тус тус оролцож байна.

Ингээд хувьцаа эзэмшигчдийн хурлын дэгийн дагуу Хурлын ирцийг мэдээлнэ үү хэмээн Тооллогын комиссын дарга С.Батбуян таныг индэрт урьж байна.

Тооллогын комиссын дарга С.Батбуян :

Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе.

“ЛэндМН ББСБ” ХК-ийн хувьцаа эзэмшигчид маань хурлын танхимд хүрэлцэн ирж <https://survey.lend.mn/> цахим хуудаст хандаж саналаа өгөх нэвтрэх нэр, нууц үг авснаар саналын эрх бүхий хувьцаа эзэмшигч нарын ирцийг бүртгэсэн байна.

Хувьцаа эзэмшигч та бүхэнд ирц бүртгүүлэхэд олгосон мандатад буй QR кодыг уншуулан <https://survey.lend.mn/> цахим хуудсанд өөрийн гар утас болон компаниас бэлтгэсэн компьютер ашиглан саналаа өгөх боломжтой. Та саналаа урьдчилан өгөх боломжтойгоос гадна ХЭЭХ-аар хэлэлцэх асуудал тус бүрийг танилцуулж, асуулт, хариулт, хэлэлцүүлэг явагдсаны дараа <https://survey.lend.mn/> цахим хуудсаар санал хураалт явагдана. Хэрэв саналаа урьдчилан өгсөн бол энэ хэсэгт дахин санал өгөх боломжгүй. ХЭЭХ-ын дэгийн дагуу санал хураалтын хугацаа дуусахад санал хураалтын цахим хуудас хаагдах тул үүнээс хойш санал өгөх боломжгүй болох ба та санал өгөх системд саналаа бүрэн гүйцэд, зөв бөглөөгүй тохиолдолд Компанийн тухай хуульд заасны дагуу саналын хуудас хүчингүйд тооцогдоно гэдгийг та бүхэн анхаараарай.

Ингээд та бүхэнд “ЛэндМН ББСБ” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын ирцийн мэдээг танилцуулъя.

Хувьцаа эзэмшигчид маань 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 18:00 цаг хүртэл брокер, дилерийн компаниудаар дамжуулан санал өгөх боломжтой байсан. Тооллогын комиссоос шалгаж үзэхэд 1 брокерын компаниас 1 (нэг) хувьцаа эзэмшигчийн саналын хуудас гэх баримтыг ирүүлсэн боловч Компанийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.2 дахь хэсэгт зааснаар “тогтоосон журмын дагуу ирүүлээгүй” байх тул саналын хуудсаар санал ирээгүйд тооцож, хурлын ирцэд тооцох урьдчилсан санал байхгүй болохыг тэмдэглэж байна.

“ЛэндМН ББСБ” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хуралд саналын эрх бүхий хувьцааны 81.64 хувийг эзэмшиж байгаа 86 хувьцаа эзэмшигчид хүрэлцэн ирж бүртгүүлсэн байх тул Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсэгт зааснаар ХЭЭХ хуралдуулах ирц бүрдэж, ХЭЭХ хүчин төгөлдөр болж байгааг хувьцаа эзэмшигчид болон ХЭЭХ-ын даргад мэдээлж байна.

ХЭЭХ зохион байгуулах комиссын дарга М.Түвшинжаргал:

Тооллогын комиссын дарга С.Батбуяндаа баярлалаа.

Одоо та бүхний өмнө “ЛэндМН ББСБ” ХК-ийн ТУЗ-ийн дарга, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дарга О.Болдбаатар таныг Хувьцаа эзэмшигчдийн хурлыг нээж, хурлын дэгийг танилцуулна уу хэмээн индэрт урьж байна.

ХЭЭХ-ын дарга О.Болдбаатар:

Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигчид ээ!

Та бүхэндээ энэ өдрийн мэндийг Төлөөлөн удирдах зөвлөл болон Компанийн нийт хамт олны өмнөөс хүргэе.

2024 он “ЛэндМН ББСБ” ХК-ийн хувьд бизнесийн өндөр өсөлтийг үзүүлсэн жил байлаа. Тус оны онцлох үйл явдлаас товч дурдвал:

1. ЛэндМН нь 2024 онд Монгол Улсад анх удаа технологийн шийдлийг ашиглан нэмэлт бичиг баримт, барьцаа хөрөнгө шаардлагагүйгээр ердөө 5 минутын дотор бизнесийн зээлийг дансандаа хүлээн авах "Flexi Business" хэмээх цоо шинэ санхүүгийн бүтээгдэхүүнийг үйлчилгээндээ нэвтрүүллээ. "Flexi Business" зээлийн бүтээгдэхүүнийг танилцуулж эхэлснээс хойш 10 сар гаруй хугацаанд давхардсан тоогоор нийт 123 мянган бизнес эрхлэгч LendMN аппликейшнээр зээлийн эрхээ тооцуулсан бөгөөд үүнээс 35 мянган удаагийн олголтоор нийт 153 тэрбум төгрөгийн бизнесийн зээлийг олгоод байна. 2024 оны эцсийн байдлаар нийт зээлийн багцын 23% нь тус бизнесийн зээлийн багцаас бүрдсэн байна.
2. “ЛэндМН ББСБ” ХК нь “Монголын Үнэт Цаасны Арилжаа Эрхлэгчдийн Холбоо” болон “Санхүүгийн Зохицуулах Хороо”-ны зөвшөөрлөөр Биржийн бус зах зээлд хаалттай хүрээнд 2 удаагийн нийт 20 тэрбум төгрөгийн бондыг гаргаж, амжилттай татан төвлөрүүлээ.
3. ЛэндМН нь 2024 оны 10 дугаар сарын байдлаар Санхүүгийн Зохицуулах Хорооноос баталсан “Компанийн засаглалын кодекс”-ыг бүрэн буюу 93% ханган ажиллалаа.
4. Бидний шинээр танилцуулсан 100% дижитал, бизнесийн барьцаагүй зээлийн үйлчилгээ болох “Flexi Business” бүтээгдэхүүн нь Сингапурын Төв Банк болон Сингапурын Финтек Холбооноос хамтран олгодог “Fintech Excellence Awards”-ийн Financial Inclusivity төрөлд нэр дэвшиж, Зүүн Өмнөд Ази цаашлаад олон улсын жижиг дунд бизнесийн санхүүгийн хүртээмжийг сайжруулахад өндөр хувь нэмэр оруулсан гэж хүлээн зөвшөөрөгдөж, эцсийн шатанд шалгарсан. Энэ нь Дижитал бизнесийн зээлийн Монголодоо төдийгүй Зүүн Өмнөд Азидаа анх удаа нэвтрүүлснийг үнэлсэн чухал үйл явдал боллоо.
5. 2024 онд гэрээт харилцагчдын тоо өмнөх жилээс 9%, цэвэр ашиг 82%, татан төвлөрүүлсэн эх үүсвэр 84%, зээлийн багц 90%-иар тус тус өссөн байна. Энэ өсөлт нь манай компанийн зээлийн үйл ажиллагаа улам бүр тэлж байгааг илэрхийлэх бөгөөд зээлийн багцын дүнгийн үзүүлэлтээр 8 жилийн түүхэнд хамгийн дээд хэмжээнд хүрсэн амжилттайгаар ажиллалаа. “ЛэндМН ББСБ” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн хурлаар компанийн нэгж хувьцаанд 15 (арван таван) төгрөгийн ногдол ашиг тооцон олгохоор тогтоож, 2024 оны цэвэр ашгийн 30.62 (гуч зууны жаран хоёр) хувийг буюу 11,089,525,245 (арван нэгэн тэрбум наян есөн сая таван зуун хорин таван мянга хоёр зуун дөчин тав) төгрөгийг хувьцаа эзэмшигчдэдээ мөнгөн хэлбэрээр хуваарилахаар шийдвэрлээд байгаа билээ.

Ингээд “ЛэндМН ББСБ” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаа эхлүүлье.

Та бүхэнд ХЭЭХ-ын дэгийг танилцуулъя.

№	Хэлэлцэх асуудал	Хугацаа	Хариуцах
1	Хурлын ирц бүртгэх	11:00-12:00	Тооллогын комисс

2	Хурлын ирцийг мэдээлэх	12:00-12:05	Тооллогын комиссын дарга
3	Хурлыг нээх, хурлын дэг танилцуулах	12:05-12:10	Хурлын дарга
4	Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайланг танилцуулах	12:10-12:20	Гүйцэтгэх захирал
5	Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэх	12:20-12:25	ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны дарга
6	Компанийн ТУЗ-ийн 2024 оны үйл ажиллагааны тайланг танилцуулах	12:25-12:40	ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны дарга
7	Компанийн ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийг танилцуулах	12:40-12:50	Хурлын дарга
8	Компанийн ТУЗ-ийн 2025 оны төсвийн саналыг танилцуулах	12:50-13:00	Гүйцэтгэх захирал
9	Компанийн дүрэмд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг танилцуулах	13:00-13:10	Гүйцэтгэх захирал
10	Хэлэлцэж байгаа асуудлуудтай холбогдсон асуулт, хариулт	13:10-13:30	Хурлын дарга Гүйцэтгэх захирал, ТУЗ-ийн хараат бус гишүүд
11	Хэлэлцэж байгаа асуудлуудаар санал хураах	13:30-13:50	Хурлын дарга, Тооллогын комиссын дарга
12	Санал хураалтын дүнг танилцуулж, тооллогын комиссын тогтоолыг батлуулах	13:50-14:20	Тооллогын комиссын дарга
13	Хурлаас гарах шийдвэрийн төсөлд Хувьцаа эзэмшигчдийн санал хураалтын дүнг тусган, танилцуулж, батлуулах	14:20-14:30	Хурлын дарга, Хурал зохион байгуулах комиссын дарга

Энэхүү дэгийн дагуу өнөөдрийн хувьцаа эзэмшигчдийн хурал маань явагдана.

Өнөөдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах үндсэн 6 асуудлыг хэлэлцэнэ. Үүнд:

1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайланг танилцуулах;
2. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэн батлах;

3. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны тайланг танилцуулах;
4. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг улируулан сонгох;
5. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны төсвийг батлах;
6. Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах.

Эдгээр асуудлуудыг хэлэлцэн батална.

ХЭЭХ зохион байгуулах комиссын дарга М.Түвшинжаргал:

“ЛэндМН ББСБ” ХК-ийн Хурлын дарга О.Болдбаатар танд баярлалаа.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийн дагуу **Хэлэлцэх асуудал №1-Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайланг танилцуулна уу** хэмээн “ЛэндМН ББСБ” ХК-ийн Гүйцэтгэх захирал Ц.Ууганбаяр таныг индэрт урьж байна.

ХЭЛЭЛЦСЭН АСУУДАЛ №1: КОМПАНИЙН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАН ТАНИЛЦУУЛАХ

“ЛэндМН ББСБ” ХК-ийн Гүйцэтгэх захирал Ц.Ууганбаяр:

“ЛэндМН ББСБ” ХК-ийн хувьцаа эзэмшигч та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе.

Бидний энэ жилийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын хамгийн эхний хэлэлцэх асуудалд болох Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайланг танилцуулахдаа таатай байна. За ингээд бүгдээрээ “ЛэндМН ББСБ” ХК-ийн 2024 оны онцлох үйл явдлуудыг дараах видеонгоос хураангуйлан харцгаая.

(2024 оны онцлох үйл явдлын талаар видео үзүүлэв)

За бидний хувьд 2024 он бол өсөлт, амжилт, ололтоор дүүрэн, өмнөх 2023 оны өсөлтийг бататгасан жил болж өнгөрлөө гэж дүгнэж байна. Бид яг жилийн өмнө та бүхэндээ ХЭЭХ-аар танилцуулж байсан 100% дижитал, барьцаагүй бичил бизнесийн зээлээ зах зээлд маш амжилттай нэвтрүүлээд ажиллаж байна. Манай апплейкшнаар орон зай, цаг хугацаанаас үл хамааран, 5 минутын дотор бизнесийн орлогоо тооцуулахаас гадна, тухайн бизнесийн төрлийг нь **ойлгон таньж, ялгах** шийдлийг Монголдоо анхлан нэвтрүүллээ.

Жижиг, өрхийн бизнес эрхлэгчид маань ихэнх нь яг өөрөө бизнесээ эрхэлдэг, тэр болгон ажлын байраа орхиод, энэ их түгжрээнд зээл хөөцөлдөөд явах цаг боломж үнэхээр хомс, зээл хөөцөлдөөд явбал дор хаяж 7 хоног гадуур бичиг баримт бүрдүүлж явна, буцаагаад энэ нь ажлаа алдах, орлого нь тасалдах нөхцөл байдал үүснэ. Энэ бол маш том зардал, алдагдсан боломж.

Дараагийн хамгийн том асуудал эдгээр жижиг дунд бизнес эрхлэгчдийн бол барьцаа хөрөнгө, уг нь одоогийн бизнесээ өргөжүүлж, орлого ашгаа тэлж, өөрсдийн гэсэн хөрөнгөтэй болох гэж хичээж байгаа иргэдээс буцаагаад барьцаа хөрөнгө байна уу гэж шаарддаг энэ хэцүү асуудлыг бид энэхүү бизнесийн зээлийн бүтээгдэхүүнээрээ шийдэж өгсөн болов уу гэж харж байна. Энэ нь цаанаа эдийн засгийг нуруун дээрээ авч яваа, чимээгүй өдөр бүр хөдөлмөрлөж хичээж байгаа жижиг дунд, өрхийн бизнесийн хамгийн тулгамдсан асуудлуудыг шийдсэн, технологийн шийдлээр санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, ЛэндМН-чүүд бидний эрхэм зорилгыг улам тод харуулсан жил боллоо гэж бид харж байна.

Цаашдаа бид энэ технологийн шийдлүүдийг ашиглан, эдгээр бичил бизнесүүдийн зөвхөн зээлийн хэрэгцээнээс гадна санхүүгийн бүх хэрэгцээ шаардлагыг нь хангасан шийдлүүдийг нэвтрүүлэх гээд ажиллаж байна. Үүний хүрээнд бид удахгүй эдгээр бичил бизнесүүдийн борлуулалтыг нэмэх, эргэлтийг сайжруулах шийдлийг энэ оны 2 дугаар улиралд багтаан зах зээлд цоо шинээр танилцуулахаар бэлэн болсон, бэлтгэл ажлаа хангаад ажиллаж байна.

Ингээд 2024 оны бизнесийн үйл ажиллагааны тоон үр дүнг товчхон танилцуулъя. Бидний шинэ харилцагчдын тоо бол өсөж байна. Өнгөрсөн онд бид шинээр аппликешнээ шинэчилж, харилцагчийн бүртгэлийн процессыг улам хялбар болгосон. Үүний үр дүнд шинээр 130 мянган бүртгэлтэй харилцагч, 18 мянган шинэ гэрээт харилцагчид нэмэгдсэн байна. За мөн зээлийн багц түүхэн дээд хэмжээ буюу 200 тэрбумын босгыг давж, 238 тэрбумд хүрлээ. Үүний 25 хувь буюу 60 тэрбум нь бидний энэ жил гаргасан бичил бизнесийн зээлээс бүрдэж байна. За мөн орлого ашиг бас багцын өсөлтийг дагаад бас өссөн үзүүлэлттэй байна.

Дээрх санхүүгийн болон бусад тоон үзүүлэлтүүдийг хөндлөнгийн хараат бус аудитын байгууллагаар хянана баталгаажуулсан санхүүгийн аудитлагдсан тайланг танилцуулъя.

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон гаргасан тайланд Санхүүгийн зохицуулах хороонд бүртгэлтэй хөндлөнгийн хараат бус аудитын компани болох “Шонхор Үнэлгээ Аудит” ХХК аудит хийж ажилласан бөгөөд энэхүү тайлан нь Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу тайлагнасан байна гэж хөндлөнгийн хараат бус аудитор дүгнэсэн байна. Та бүхэн аудитлагдсан дэлгэрэнгүй тайлантай www.lend.mn гэсэн компанийн албан ёсны веб хуудсаар орж танилцах боломжтой. Өнөөдрийн хурлын асуулт, хариулын хэсэгт та бүхэн аудитлагдсан тайлантай холбоотой сонирхсон асуултаа асуух боломжтой.

Баярлалаа.

ХЭЭХ зохион байгуулах комиссын дарга М.Түвшинжаргал:

Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайланг танилцуулсан “ЛэндМН ББСБ” ХК-ийн Гүйцэтгэх захирал Ц.Ууганбаяртаа баярлалаа.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийн дагуу Хэлэлцэх асуудал №2-Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэн батлах асуудлын тухай хэлэлцэнэ. Та бүхнийхээ өмнө “ЛэндМН ББСБ” ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүн, ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны дарга Ж.Жаргалсүрэнг урьж байна.

ХЭЛЭЛЦСЭН АСУУДАЛ №2: КОМПАНИЙН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТАЛААРХ ТУЗ-ИЙН ДҮГНЭЛТИЙГ ХЭЛЭЛЦЭХ

“ЛэндМН ББСБ” ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүн, ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны дарга Ж.Жаргалсүрэн:

Та бүхэн дэлгэцээс харж байгаачлан ТУЗ-ийн 2025 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн хурлаар Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлантай танилцсан. Санхүүгийн аудитлагдсан тайлангийн хувьд ямарваа нэг материаллаг зөрчил илрээгүй, Монгол Улсын болон олон улсын тайлагналын стандартын дагуу тайлан маань бэлтгэгдсэн тул ТУЗ-ийн зүгээс 25/01 тоот тогтоолоор аудитлагдсан тайланг хүлээн зөвшөөрсөн болно. Мөн

Компанийн 2024 оны үйл ажиллагааг ТУЗ-ийн зүгээс “Хангалттай” хэмээн дүгнэж, 25/02 тоот тогтоолыг гаргасан байна.

Компанийн 2024 оны тайланд Санхүүгийн зохицуулах хороонд бүртгэлтэй “Шонхор Үнэлгээ Аудит” ХХК хараат бус аудит хийж ажилласан. Мөн энэ жилийн хувьд ч бид өмнөх жилтэй адилаар олон улсын хамгийн шилдэг аудитын компани болох “Эрнст энд Янг Монголия Аудит” ХХК-ийг нэмэлтээр ажиллуулж, компанийн 2024 оны санхүүгийн тайланг давхар баталгаажуулсан.

Хараат бус аудитын байгууллагуудын дүгнэлтүүд хооронд ямар нэгэн зөрүү гараагүй болохыг цохон тэмдэглэмээр байна.

Иймд өнөөдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар “ЛэндМН ББСБ” ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрч, баталж өгөхийг Хувьцаа эзэмшигч та бүхнээс хүсэж байна.

Баярлалаа.

ХЭЭХ зохион байгуулах комиссын дарга М.Түвшинжаргал:

Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг танилцуулсан “ЛэндМН ББСБ” ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүн, ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны дарга Ж.Жаргалсүрэн танд баярлалаа.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийн дагуу **Хэлэлцэх асуудал №3-Компанийн ТУЗ-ийн 2024 оны үйл ажиллагааны тайланг** танилцуулна уу хэмээн “ЛэндМН ББСБ” ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүн, ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны дарга Ж.Жаргалсүрэн таныг үргэлжлүүлэн урьа.

ХЭЛЭЛЦСЭН АСУУДАЛ №3: КОМПАНИЙН ТУЗ-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН ТАНИЛЦУУЛАХ

“ЛэндМН ББСБ” ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүн, ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны дарга Ж.Жаргалсүрэн:

Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе.

Төлөөлөн удирдах зөвлөл нь Компанийг ерөнхий удирдлагаар хангаж, хяналт тавихын зэрэгцээ Гүйцэтгэх удирдлагад компанийн үйл ажиллагааг үр ашигтай, үр дүнтэй удирдахад нь шаардлагатай чиглэлийг өгч ажилладаг.

ТУЗ эрх үүргээ бүрэн хэрэгжүүлж, үйл ажиллагаагаа үр дүнтэй явуулах зорилгын хүрээнд Компанийн дүрэм, ТУЗ-ийн Үйл ажиллагааны журмаар тодорхойлсон, тодорхой чиг үүрэг, байнгын ажиллагаа бүхий 1/ Эрсдэлийн удирдлагын хороо, 2/ Аудитын хороо, 3/ Засаглал, нэр дэвшүүлэх хороо болон 4/ Цалин урамшууллын хороодтой.

2024 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн ХЭЭХ-аар томилогдсон ердийн 6, хараат бус 3 гишүүний бүрэлдэхүүнтэй ТУЗ хууль дүрмийн дагуу үйл ажиллагаагаа явуулж ирлээ. Компанийн ТУЗ нь өнгөрсөн нэг жилийн хугацаанд 5 удаа ээлжит, 1 удаа ээлжит бусаар хуралдан нийт 43 тогтоол гаргажээ. ТУЗ-өөс гарсан бүх тогтоолуудыг холбогдох журамд заасны дагуу Монголын хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлж ажиллалаа.

2024 онд Компанийн зээлийн үйл ажиллагааны өдрөөс өдөрт өсөн нэмэгдэж буй эрэлтийг хангах, эх үүсвэрийг нэмэгдүүлэх үүднээс холбоотой талтай хийсэн нийт 2 сонирхлын

зөрчилтэй хэлцэлд Компанийн ТУЗ-өөс Монгол Улсын Компанийн тухай хуульд заасан журмын дагуу зөвшөөрөл олгосон байна.

Энэхүү хэлцлүүд нь Компанийн үндсэн үйл ажиллагааг санхүүжүүлэх зорилгоор холбоотой талаас санхүүжилт татан төвлөрүүлэх болон Нийгэмд ээлтэй, тогтвортой үйл ажиллагаа эрхэлдэг бизнес эрхлэгчдэд зээл олгох үйл ажиллагааг эрчимжүүлж байгаа тул холбоотой талд зээл олгохтой холбоотой байсан.

2.Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодын үйл ажиллагааг танилцуулъя.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хороо:

Эрсдэлийн удирдлагын хороо нь тайлант жилийн хугацаанд нийт 4 удаа хуралдаж, Компанийн бизнесийн хөгжил, эрсдэл болон эх үүсвэрийн үйл ажиллагааны бодлогыг тодорхойлох, учирч болзошгүй эрсдэлийг оновчтой удирдан чиглүүлэхэд дэмжлэг үзүүлэх, нөхцөл байдалтай тухай бүр танилцан хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлэн ажилласан байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хороо:

Аудитын хороо нь тайлант жилийн хугацаанд нийт 4 удаа хуралдаж, Компанийн дотоод хяналтын тогтолцооны хэрэгжилтэд хяналт тавьж, дотоод аудиторын үйл ажиллагааны тайлантай тухай бүр танилцан шаардлагатай санал, зөвлөмжийг холбогдох албан тушаалтнууд болон Компанийн газар, албадад өгч ажиллалаа. Түүнчлэн, Компанийн зүгээс хийсэн сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаар дүгнэлт гаргах, Компанийн санхүүгийн тайланг баталгаажуулах хөндлөнгийн аудитын байгууллагыг томилох, Компанийн үйл ажиллагаа нээлттэй, ил тод байлгахад анхаарч мэдээллийг тухай бүр олон нийтэд хүргэж буй эсэхэд хяналт тавьж ажилласан байна. “ЛэндМН ББСБ” ХК-ийн 2024 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон нэгтгэсэн болон тусдаа санхүүгийн тайланд дүгнэлт гаргуулахаар хөндлөнгийн аудитын байгууллагуудтай хийсэн гэрээний дүн 258.1 сая төгрөг байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх хороо:

Засаглал, нэр дэвшүүлэх хороо нь тайлант жилийн хугацаанд нийт 1 удаа хуралдаж, ТУЗ-ийн гишүүдийг улируулан сонгох, ТУЗ-ийн ердийн болон хараат бүс гишүүдийг шинээр сонгох асуудлыг хэлэлцэн Компанийн ХЭЭХ-д танилцуулан шийдвэрлүүлэх тухай шийдвэрлэж, мөн Компанийн мөрдөж буй ажлын үр дүнтэй холбоотой урамшууллын системийн хэрэгжилттэй холбоотой зөвлөмжийг холбогдох албан тушаалтнуудад өгч, гүйцэтгэх захирлын томилгоо, гүйцэтгэх захирлын урамшуулалтай холбоотой дүгнэлт гарган ажилласан байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Цалин, урамшууллын хороо

Цалин, урамшууллын хороо нь ТУЗ-ийн 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 24/17 дугаартай “Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” тогтоолоор шинээр байгуулагдсан бөгөөд Компанийн ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх захирлын цалин, урамшууллын талаар баримтлах бодлогыг батлах, хэрэгжилтэд хяналт тавих, ажиллагсдын тэтгэврийн даатгалын болон хувьцаа эзэмшүүлэх аливаа хөтөлбөрийг судалж, сонголт хийх гэх мэт чиг үүргийг хэрэгжүүлж ажилласан байна. Энэ хороо нь мөн 1 тайлант жилийн хугацаанд нийт 1 удаа хуралджээ.

Компанийн ТУЗ-ийн гишүүд нь Монгол Улсын Компанийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын Хөрөнгийн биржийн холбогдох журам, кодекс, түүнчлэн Компанийн дүрэм, ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэн ажилладаг бөгөөд аливаа шийдвэрийг хараат бусаар, бие даан гаргадаг. ТУЗ-

ийн аливаа шийдвэр нь олонхын саналаар хүчин төгөлдөр болдог ба ТУЗ-ийн гишүүн нь хэлэлцэж буй асуудлаар “дэмжсэн”, “татгалзсан”, “түдгэлзсэн” санал гаргах боломжтой. ТУЗ-ийн гишүүд нь тайлант хугацаанд чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж, хичээл зүтгэл гарган ажилласан гэдгийг ТУЗ-ийн хурлын ирцээс харж болно.

2024 оны 03 дугаар сарын 30-ны өдөр зохион байгуулсан Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар ТУЗ-ийн 2024 оны цалингийн хэмжээ, зарцуулах төсвийг баталсан бөгөөд уг батлагдсан төсвийн хүрээнд ТУЗ нь үйл ажиллагаа явуулсан байна. ТУЗ-ийн гишүүдэд нэмэлт урамшуулал, шагнал, аливаа нөхөн олговор олгоогүй болно.

Баярлалаа.

ХЭЭХ зохион байгуулах комиссын дарга М.Түвшинжаргал:

Компанийн ТУЗ-ийн 2024 оны үйл ажиллагааны тайланг танилцуулсан “ЛэндМН ББСБ” ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүн, ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны дарга Ж.Жаргалсүрэн танд баярлалаа.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийн дагуу **Хэлэлцэх асуудал №4-Компанийн ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд улиран сонгогдохоор дэвшиж буй нэр дэвшигчдийг танилцуулна уу** хэмээн ТУЗ-ийн дарга, ХЭЭХ-ын дарга О.Болдбаатарыг урьж байна.

ХЭЛЭЛЦСЭН АСУУДАЛ №4: КОМПАНИЙН ТУЗ-ИЙН ГИШҮҮДИЙГ УЛИРУУЛАН СОНГОХ ЭСЭХ

ХЭЭХ-ын дарга О.Болдбаатар:

2024 оны 03 дугаар сарын 30-ны өдөр болсон хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар ТУЗ-ийн 1 хараат бус гишүүн, 2 ердийн гишүүн шинээр сонгогдож ажилласан. ЛэндМН-ийн хувьд 2024 онд өмнөх жилүүдтэй харьцуулахад өндөр ололт амжилттай жил байсан нь компанийг нийт Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд оновчтой удирдан чиглүүлж ажилласны үр дүн гэж үзэж байна. Иймд ТУЗ-ийн нийт гишүүдийг Компанийн ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын 3 дугаар зүйлийн 3.1, 3.2, 3.3-т заасан компанийн ТУЗ-ийн гишүүнд тавигдах шалгуурыг бүрэн хангасан бөгөөд ёс зүйн өндөр төлөвшилтэй, эдийн засаг болон санхүүгийн зах зээлийн боловсрол хангалттай эзэмшсэн, бизнесийн салбарт амжилттай мэргэшиж байгаагаа баталж чадсан гэж үзэж улируулан сонгох саналтай байна.

Ингээд та бүхэн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд улиран сонгогдохоор нэр дэвшигчдийн дэлгэрэнгүй танилцуулгыг дараах бичлэгээс үзнэ үү.

(Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчдийн дэлгэрэнгүй танилцуулга видео үзүүлэв)

ХЭЭХ зохион байгуулах комиссын дарга М.Түвшинжаргал:

Компанийн ТУЗ-ийн бүрэлдэхүүн, ердийн болон хараат бус гишүүнд улиран сонгогдохоор нэр дэвшиж буй нэр дэвшигчийн танилцуулгатай танилцлаа.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийн дагуу **Хэлэлцэх асуудал №5-Компанийн ТУЗ-ийн 2025 оны төсвийн саналыг танилцуулна уу** хэмээн “ЛэндМН ББСБ” ХК-ийн Гүйцэтгэх захирал Ц.Ууганбаяр таныг индэрт урьж байна.

ХЭЛЭЛЦСЭН АСУУДАЛ №5: ТУЗ-ИЙН 2025 ОНЫ ТӨСВИЙГ БАТЛАХ

“ЛэндМН ББСБ” ХК-ийн Гүйцэтгэх захирал Ц.Ууганбаяр:

“ЛэндМН ББСБ” ХК-ийн хувьцаа эзэмшигчид та бүхэндээ Компанийн ТУЗ-ийн 2025 оны төсвийн санал танилцуулж байна. 2024 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын шийдвэрээр батлагдсан ТУЗ-ийн 2024 оны төсвийг мөн 2025 онд өөрчлөхгүй байхаар саналыг оруулж байна.

ТУЗ-ийн 2025 оны нийт төсөв нь 196 сая төгрөг байна.

Иймд Хувьцаа эзэмшигч та бүхнийг ТУЗ-ийн 2025 оны төсвийг батлах санал хураалтад саналаа өгөхийг хүсэж байна.

ХЭЭХ зохион байгуулах комиссын дарга М.Түвшинжаргал:

Компанийн ТУЗ-ийн 2025 оны төсвийн саналыг танилцуулсан “ЛэндМН ББСБ” ХК-ийн Гүйцэтгэх захирал Ц.Ууганбаяртаа баярлалаа.

Үргэлжлүүлэн Хэлэлцэх асуудал №6-Компанийн дүрэмд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг танилцуулна уу хэмээн хүсье.

ХЭЛЭЛЦСЭН АСУУДАЛ №6: КОМПАНИЙН ДҮРЭМД ОРУУЛАХ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТИЙН ТӨСӨЛ

“ЛэндМН ББСБ” ХК-ийн Гүйцэтгэх захирал Ц.Ууганбаяр:

Бид Компанийн дүрэмд дараах нэмэлт өөрчлөлтүүдийг оруулах саналыг гаргаж байна. Үүнд:

Нэгдүгээрт, Компанийн дүрмийн 2.2 дахь хэсэгт заасан компанийн албан ёсны хаягийн өөрчлөлтийг оруулах юм. Тодруулбал, 2024 оны 12 дугаар сарын 16-ны өдрөөс эхлэн Компанийн удирдлага болон алба хэлтсүүд нь өөрчлөлт оруулж буй хаягт шилжин ирж, үйл ажиллагаагаа явуулж байгаа тул Компанийн албан ёсны хаягийн өөрчлөлтийг Компанийн дүрэмд оруулах шаардлагатай байна.

Хоёрдугаарт, Компанийн дүрмийн 4.2.9 дэх хэсэгт заасан компанийн үйл ажиллагааны чиглэл нэмэх санал байгаа. Компани нь өөрийн 100% эзэмшлийн охин компани болох “ЛэндМН СМЭ ББСБ” ХХК-ийн үйл ажиллагааг эхлүүлж байгаатай холбоотойгоор охин компани нь гуравдагч этгээдээс хөрөнгө оруулалт шууд татахад тус компанийн үйл ажиллагаа жигдрээгүйтэй холбоотойгоор толгой компанийн зүгээс хөрөнгө оруулагчдын өмнө “Төлбөрийн баталгаа гаргах” шаардлага үүсэж байгаа болно. Монгол Улсын Компанийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.6 дахь заалтад “Компанийн дүрэмд компанийн үйл ажиллагааны чиглэлийг заавал тусгана” гэж заасны дагуу бид Компанийн дүрэмд уг үйл ажиллагааны чиглэлийг нэмж оруулан, Зохицуулагч байгууллагаас тус үйл ажиллагааг эрхлэх зөвшөөрлийг авах шаардлагатай байгаа юм.

Баярлалаа.

ХЭЭХ зохион байгуулах комиссын дарга М.Түвшинжаргал:

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийн дагуу Хэлэлцэж байгаа асуудлуудтай холбогдсон асуулт, хариултын хэсэг эхэлж байна. Та бүхэн гараа өргөөд чөлөөтэй асуулт асууж, хариултаа авах боломжтой. Мөн санал хураалтын цахим системээр ирүүлсэн асуултуудыг асуух болно.

Ингээд индэрт “ЛэндМН ББСБ” ХК-ийн

ТУЗ-ийн дарга, Хувьцаа эзэмшигчдийн хурлын дарга О.Болдбаатар

ТУЗ-ийн Хараат бус гишүүн, Аудитын хорооны дарга Ж.Жаргалсүрэн

Компанийн ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирал Ц.Ууганбаяр
Компанийн Бизнес хөгжлийн газрын захирал Ж.Сосор
Компанийн Хамтын ажиллагаа хариуцсан захирал Х.Энхжаргал нарыг урьж байна.

Та бүхэн өнөөдрийн хуралд оролцож байгаа албан тушаалтнуудаа хүссэн асуултаа, чөлөөтэй асуух боломжтой. Зааланд манай зохион байгуулагчид микрофоноо асуулт асуух хүмүүс рүү шилжүүлээд өгөөрэй.

АСУУЛТ/ХАРИУЛТЫН ХЭСЭГ:

Асуулт 1: Сайн байцгаана уу? Би өөрийн охин болон өөр дээрээ хувьцаа цуглуулдаг. Надад нэг хэдэн асуулт байгаа юм. 1-т Би сая 12 цаг 07 минутад орж ирээд хоцорсон, санал өгөх боломжгүй болсон. Танай ТУЗ-д хуульч хүн нэр дэвшиж байх шиг байна. Тэр хүнээс асуумаар байна. Миний хувьд 10:00 цагт и-мэйлээр төрсний гэрчилгээ болон иргэний үнэмлэхийн лавлагаагаа илгээж, хүсэл зоригоо Иргэний хуулийн 42.1-т заасны дагуу цахимаар илэрхийлсэн. Тэгэхээр танайх и-мэйлээ шалгаад бүртгэх нь зөв үү? эсвэл бүртгэхгүй байх нь зөв үү? Энэ дээр хуулийн үндэслэл байгаа бол хэлж өгнө үү.

Хоёрт гэвэл санхүүчид дийлэнх хувийг нь эзэлдэг юм байна гэж ойлголоо. Тэгэхээр би танилцуулга дээрх тоог сайн харж чадаагүй учраас асууж байгаа юм. Миний хувьд 151 гаруй компанийн хувьцаатай, нэг ширхэг, олон ширхэг гээд цуглуулсан ирээдүйд бол үнэ цэн нь өсөх байх. Нэмж ЛэндМН-ийг авахад бол сонирхол татаж байна, танилцуулга харахад. Би дансны үнэ гэдэг үзүүлэлтийг их харж авдаг. Нийт хөрөнгөөс өр төлбөрийг хасаад эздийн өмч гарч байгаа. Эздийн өмчийг нийт гаргасан хувьцаанд нь хуваахаар дансны үнэ гараад байгаа. Энэ дансны үнэ нь одоогийн зах зээлийн ханшнаас өндөр байх юм бол би хувьцааг нь цуглуулж авдаг. Тэгэхээр дансны үнэ хэд байгаа вэ? Өнөөдрийн зах зээлийн ханшнаас ЛэндМН-ийн дансны үнэ өндөр байна уу? Хэдэн хувьтай байгаа вэ? Энэ талаар мэргэжлийн хүнээс нь асуумаар байна.

Гуравт гэвэл нарийн бичгийн даргын цалин хөлсний хэмжээ сая харагдаж байна. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 660,000 байгаа, тэтгэврийн хөгшчүүл хамгийн багадаа ийм авч байгаа. Нарийн бичгийн цалин чинь 650,000 төгрөг байгаа нь Хөдөлмөрийн тухай хуулиа зөрчиж байна уу? Одоо 4 сарын 1-ний өдрөөс хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 750,000 төгрөгөөс дээшээ болж нэмэгдэж байна. Тэгэхээр нарийн бичгийн эрх зүйн байдлыг дордуулж байгаа зүйл харагдлаа. Энэ дээр хуульчдаасаа хариулт өгнө үү.

Баярлалаа.

Хариулт, ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга Б.Оюунболд: Таны асуултад баярлалаа. Би “ЛэндМН ББСБ” ХК-ийн ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга, өөрөө эрх зүйч мэргэжилтэй, хуульч. Энэ компанид 6 дахь жилдээ, ТУЗ-ийн Нарийн бичгийн даргаар 3 дахь жилдээ ажиллаж байна. Тэгэхээр таны эхний асуулт болон 3 дахь асуулттай холбоотой хариултыг би өгөх нь зөв юм болов уу гэж бодож байна.

Эхний асуултын хувьд бол 2025 оны 02 дугаар сарын 06-ны өдөр Компанийн ТУЗ-ийн зүгээс хувьцаа эзэмшигчдийн хурлын зараа батлахдаа давхар дэгээ баталсан байдаг. Бид энэ дэгийг ямар үндэслэлээр, яаж баталдаг вэ гэхээр Санхүүгийн зохицуулах хорооноос 2018 онд батлаад 2021 оны 45 дугаар тогтоолоор нэмэлт, өөрчлөлт орсон Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам байгаа, энэ журамд хурлынхаа зарыг яаж

хүргэх вэ гэдгээс эхлээд дэг нь өөрөө ямар байх ёстой, мөн ямар үндэслэлүүдээр хурлаа зохион байгуулах вэ гэсэн зохицуулалтыг хийж өгсөн. Тэгэхээр энэ тохиолдолд энэ журамд хуралд оролцохоор хүсэлт гаргагчийн биеийн байцаалт, итгэмжлэлээр оролцож буй бол түүнийг үндэслээд хувьцаа эзэмшигчдийн жагсаалттай тулган баталгаажуулна, хуралд оролцох эрх бүхий этгээдийг танин баталгаажуулах талаар заасан. Бид дэгээ батлахдаа бол та биечилж ирээд өөрийнхөө баримт бичгийг шалгуулна гэдэг зохицуулалт хийж өгсөн. Бид бүхэн ямараа нэг байдлаар ирсэн тэр цахим шууданг үндэслээд бүртгэл хийх боломжгүй байсан юм. Таныг бас үүнийг ойлгоорой гэж хүсье.

Таны асуусан 3 дахь асуултын хувьд бол нарийн бичгийн цалингийн талаар байсан. Ер нь бол нарийн бичгийн дарга маань манай компанийн хувьд, за нийтлэг жишгээрээ ч тэр бусад компанийн хувьд хавсран байдалтай байна. Тэгэхээр би энэ компанийн хуульчаар ажиллаж байгаа учраас хуульчийнхаа хувьд цалин авч байгаа, мөн ТУЗ-ийн Нарийн бичгийн даргаар ажиллаж байгаа учраас яг тэр ажлынхаа цагт тохирсон цалин хөлсийг аваад явж байгаа юм. Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийг 1-т зөрчсөн асуудал болоогүй, 2-т ТУЗ-ийн Нарийн бичгийн даргын эрх зүйн байдал буюу статусыг дордуулсан зүйл болоогүй гэдгийг цохон тэмдэглэмээр байна. Баярлалаа.

Хариулт, Гүйцэтгэх захирал Ц.Ууганбаяр: 2 дахь асуултад хариульъя. 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн аудитлагдсан тайлан манай тараасан материал дунд байгаа юм. Эздийн өмч бол 72 гаруй тэрбум төгрөг байна, эргэлтэд бол нийт 739 сая гаруй хувьцаа байна. Нэгж хувьцааны дансны үнэ нь 95 орчим төгрөг болж байна. Өнөөдөр ханш бол 140 гаруй төгрөг байна.

Асуулт 2: Сайн байна уу, юуны өмнө 2024 онд амжилттай ажилласан нийт менежментийн багт баяр хүргэе. Миний асуулт бол сайн засаглал талаасаа, ТУЗ-ийн хараат бус гишүүдийн тоог нэмэгдүүлэх санал байна. ТУЗ-ийн гишүүдийг харвал ганц хуульч бусад нь бол нягтлан бодох бүртгэл, аудит гэсэн чиглэлээр төвлөрсөн байна. Тэгэхээр сайн засаглал гэхээр ТУЗ талдаа олон мэргэжилтнээс бүрдэх юм болов уу гэж ойлгодог. Хараат бус гишүүдийн тоог нэмэх, ТУЗ-ийн бүтцийг олон мэргэжилтнээс бүрдүүлэх тийм бодлого байна уу? 2-т гэвэл 2025 оны макро эдийн засгийн нөхцөл байдлыг юу гэж харж байна вэ? Бизнесийн зээл дээр төвлөрч байгаа нь хэр оновчтой шийдэл гэж харж байна вэ?

Хариулт, ХЭЭХ-ын дарга О.Болдбаатар: ТУЗ-ийн 9 гишүүн, үүнээс 3 нь хараат бус гишүүд байгаа. Энэ маань Компанийн тухай хуулиараа хувьцаат компаниас шаарддаг шаардлагын хүрээнд байгаа тоо. Хараат бус гишүүдийн тоог нэмэх дээр хэлэлцэх асуудал маань гараад явчихсан учраас энэ удаад ингэж орлоо. Хараат бус гишүүний тоог нэмэх боломж байгаа, түүнийг бид дараагийн удаагийн ТУЗ-ийн бүрэлдэхүүн дээр анхаарах болно. ТУЗ-д байгаа гишүүдийн бүрэлдэхүүний хувьд бид аль болох тал талын салбарын төлөөллийг зорьдог. Өнгөрсөн жилийн хувьд хараат бус гишүүнээр орж ирсэн С.Нэргүй гишүүний хувьд маш олон жил энэ бичил зээл, бизнесийн зээл дээр ажиллаж байсан туршлагатай. Бид ч гэсэн энэ Flexi гээд бизенсийн зээл гаргаад явж буй учраас энэ хүний туршлага компанийн үйл ажиллагаанд хувь нэмэр болно гэж бодоод оруулж ирсэн.

Асуулт 3: Сайн байна уу, Өнөөдрийн хуралд жоохон хоцорч орж ирсэнд уучлаарай. 2024 онд мундаг ажилласан ЛэндМН-ийн бүх хамт олонд баярлалаа. Танилцуулгаас миний асуух гэсэн зүйл бол санхүүгийн үйл ажиллагаа, тайлантай холбоотой. 2024 онд хэдийг төлөвлөөд, гүйцэтгэл нь хэд болоод одоо 82%-ийн цэвэр өсөлт, ашигтай гарав аа гэдгээ тайлбарлах, эсвэл графикаар оруулсан бол илүү гоё тайлан харагдахаар байлаа. 2-т гэвэл 2025 онд ЛэндМН-ийн хувьд төсөөллөө яаж харж байна вэ? Цэвэр ашгаа одоо 2025 онд яаж харж байна вэ? 2025 онд таамаглал ямар байна вэ? Одоо

хэдхэн хоногийн дараа санхүүгийн I улирал дуусах гэж байна тэгэхээр 2025 оны таамаглал хэр байна вэ? 2024 оноо дахиад давтаж чадах уу?

Хариулт, Бизнес хөгжлийн газрын захирал Ж.Сосор: Сайн байна уу, за ямартай ч өмнөх хүний асуусан 2 дахь асуултад эхлээд хариулах нь зөв байх. Дараа нь таны асуулт руу шилжье.

Бид 2024 онд өөрийн стратегийг хэрэглээний зээлээс илүү бизнесийн зээл рүү шилжүүлсэн. Энэ шилжилт нь хэд хэдэн шалтгаантай. Бид харилцагчийнхаа 2017 оноос хойших дата мэдээллийг үзээд мөн уулзаад явж байхад авсан мэдрэмж нь манай харилцагчид цалингийн орлогоос гадна тодорхой хэмжээний нэмэлт орлоготой, бизнес эрхэлж байсан хүмүүс дийлэнх хувийг эзэлж байсан. Манай зээл дээр тэр хүмүүс өдөр тутмынхаа эргэлтийн хөрөнгийн санхүүжилтийг ашиглах хүсэлтэй байсан учраас бид энэ зээлийг гаргах нь зөв гэж шийдсэн. Мөн өнгөрсөн оноос хэрэглээний зээл маань хэт өсөлттэй байсан, зах зээл өөрөө ханаж байгаа, түүнчлэн зохицуулагч байгууллагаас энэ төрлийн зээлийг чангалах бодлого барьж буй учраас энэ зээлрүү явсан нь зөв гэж харж байна. Энэ жил салбарын зохицуулалтууд чангараад эхэлж байна.

Хариулт, Гүйцэтгэх захирал Ц.Ууганбаяр: Таны асуултад би хариулъя. 2025 он гараад 3 сар болж байна. Бид 2 сард ТУЗ-ийн хурлаараа энэ жилийн төсөв, төлөвлөгөөгөө батлаад байна. Тэрнээс хойш гэвэл СЗХ болон Монголбанкнаас хэрэглээний зээлийн өсөлттэй холбоотой хумих зохицуулалт гаргаж эхэлж байна. Нэг талаараа зээл олголт буюу өр, орлогын харьцааг бууруулсан, энэ нь гэхдээ бид бизнесийн зээл дээр төвлөрч байгаа учраас шууд буух нөлөөлөл харьцангуй гайгүй болов уу гэж бодож байна. Бас эх үүсвэр дээр, бонд, итгэлцэл, зээл гээд хязгаарлалт чангатгаж орж ирсэн. Тэгэхээр энэ жил бид 2025 онд эх үүсвэр хумигдаж буй учраас өөр боломж, гадны эх үүсвэрийг татаж ажиллана гэж бодож байна. Багц маань 237 орчим тэрбум төгрөг байгаа, түүнийг ямартай ч 300 тэрбумд дөхүүлнэ гэж зорьж байна. Мэдээж явцын дунд эрсдэлийг сайн харна. Бид мөн худалдаа, үйлчилгээний салбарт төвлөрч байгаа учраас эрсдэлээ удирдах боломжтой гэж дүгнэж байна.

Асуулт 4: Сайн байна уу, энэ зах зээл өөрөө өрсөлдөөнтэй зах зээл. Энэ зах зээлд өндөр амжилттай ажиллаж буй та бүхэнд баяр хүргэе. ЛэндМН-ийн хамт олонд итгэдэг, итгэсээр ч байх болно. Нэг асуулт байгаа нь саяхан Лондонгийн хөрөнгийн бирж дээр Инвескор ББСБ гарсан байгаа. Тэгэхээр ЛэндМН-ийн хамт олонд олон улсын зах зээл дээр гарах зорилт байгаа юу?

Хариулт, Гүйцэтгэх захирал Ц.Ууганбаяр: Санхүүгийн салбараас анх удаагаа Инвескор ББСБ Лондонгийн хөрөнгийн бирж дээр хувьцаагаа бүртгүүлсэн нь нэлээн том мөс хагалсан үйл явдал болсон гэж харж байна. Энэ нь санхүүгийн эх үүсвэрээ төрөлжүүлэх зорилготой байсан юм болов уу гэж бодсон. ЛэндМН-ийн хувьд бол эхний ээлжид боломжит бүх эх үүсвэрийн арга хэрэгсэл дээр төвлөрч ажиллана. Явцын дунд бид нэмж хувьцаа гаргах, эздийн өмчийн томруулах төлөвлөгөө гаргахыг үгүйсгэхгүй. Хэрэв тийм бол бид тухайн үед нь та бүхэнд бас мэдэгдэж, зөвшөөрөл авах байх.

Асуулт 5: ТУЗ-ийн гишүүд яагаад ЛэндМН-ээс хувьцаа авахгүй байгаа вэ? Сая харахад маш бага хувьцаа эзэмшиж байна. Ирээдүйдээ итгэлгүй байна уу?

Хариулт, ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга Б.Оюунболд: Тэгэхээр үнэт цаасны зах зээлд дотоод мэдээлэл эзэмшигч гэдэг ойлголт байдаг. Энэ нь юуг илэрхийлдэг вэ гэхээр хувьцааны ханшид өөрчлөлт оруулж болохуйц ямар нэгэн ач холбогдол бүхий мэдээллийг бусдаас хамгийн түрүүнд мэдэх боломжтой ийм этгээдийг хэлж байгаа. ТУЗ-ийн

гишүүдийн хувьд яг энэ мэдээлэл дээр ажилладаг буюу компанийн өдөр тутмын үйл ажиллагаанаас гадна, цаашдын ирээдүйтэй холбоотой ач холбогдол бүхий мэдээллийг сонсох, тэрийгээ үндэслээд шийдвэр гаргадаг учраас өөрийн ажиллаж буй компанийн хувьцааг авах, зарах үйл ажиллагаа нь хязгаарлагдмал байдаг. ТУЗ-ийн гишүүдийн хувьцааны эзэмшлийн талаар жил бүр бил тайлан дээрээ тусгаж байгаа, ихэнхи гишүүд маань ТУЗ-д сонгогдохоосоо өмнө 2018 онд хувьцаа эзэмшиж байсан, тэрнээс хойш өөрчлөлт ороогүй буюу эзэмшиж буй байдлаараа байгаа чигээр явж байна гэсэн үг. Түүнээс гадна ач холбогдолтой мэдээллийг мэдэж байгаа гэдгээрээ ТУЗ-ийн нарийн бичгийн дарга миний бие ч гэсэн хувьцаа арилжаанд хамаагүй оролцож болдоггүй байгаа юм.

Асуулт 6: Ашиг нэмэгдэж байгаа тул ногдол ашиг нэмэгдэх үү?

Хариулт, Гүйцэтгэх захирал Ц.Ууганбаяр: 2018 онд IPO хийснээсээ хойш бид ногдол ашгийг жил бүр дор хаяж 25-30 хувьтай зарлаж байна. Сүүлийн жилд ашиг, орлого өсөж буйтай холбогдуулан нэгж хувьцаанд зарласан ногдол ашгийн өгөөж бол өндөр явж байна. Яг хэмжээг бол ТУЗ-ийн зүгээс тодорхойлно, баримт бичгээ бариад. ТУЗ бол ногдол ашиг тарааж хувьцаа эзэмшигчид өгөөж өгөх нь зүйтэй гэдэг байр суурийг барьдаг учраас бид цаашдаа дор хаяж 20%-тай байлгана. Гэхдээ эцсийн шийдвэрийг ТУЗ гаргана.

Асуулт 7: Харилцагчийг хамгаалах сертификат авсан гэж байсан. Энэ ямар учиртай вэ?

Хариулт, Хамтын ажиллагаа хариуцсан захирал Х.Энхжаргал: Харилцагчийг хамгаалах сертификатыг бид саяхан шалгуулаад 2025 оны 2 сарын сүүлээр эцсийн үр дүнгээ хүлээж авсан. Тэгэхээр энэ сертификатын учир нь хөрөнгө оруулагч нар миний хөрөнгө оруулсан компани зөв зохистой үйл ажиллагаатай байна уу, зээл олгож байгаа харилцагчдадаа ямар нэгэн дарамт шахалт үзүүлж байна уу, тэдгээрийн эрх ашгийг хамгаалж чадаж байна уу гэдгийг нэг бүрчлэн үнэлж, хянаж чаддаггүй. Тэгэхээр үүнийг нь хийж огдог олон улсын хөндлөнгийн аудитын байгууллагаар бид сая үнэлгээ хийлгэсэн. Энэ үнэлгээ өнчрсөн сарын 9 сараас эхлээд бараг хагас жил үргэлжлээд эцэст нь бид Алт, Мөнгө, Хүрэл гэсэн сертификат өгдгөөс бид Мөнгийг нь авч чадсан байгаа. Энэ сертификатыг авснаараа хөрөнгө оруулагчдад энэ компани харилцагчаа хүндэлдэг, буруу үйл ажиллагаа явуулдаггүй гэдгийг нотолж байгаа, нөгөө талаар харилцагчид миний зээл авч байгаа энэ компани хүү, шимтгэлээ ил тод, нээлттэй зарладаг, ямар нэгэн нууц хүү, шимтгэл байхгүй юм байна, мэдээллийн аюулгүй байдлыг хангаж байгаа гэсэн процессыг баталж өгч байгаа юм. Энэ үнэлгээг олон улсдаа банк, бичил зээл олгодог санхүүгийн байгууллагууд, даатгалын компаниуд хийлгэдэг юм билээ. Энэ үнэлгээний хувьд бид дэлхийд анх удаа бүрэн дижитал зээл дээр хийгдсэн сертификатын эзэд болсон гэдгийг дуулгахад таатай байна.

Асуулт 8: Зээлийн авлагын талаар асуумаар байна. Нийт хэдэн төгрөгийн авлага шүүхийн шийдвэр гүйцэтгэл дээр очсон байгаа вэ? Ер нь төлөгдөөгүй зээл хэд байгаа вэ? 2-т гэвэл үндэсний үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнийг борлуулахад хөшүүрэг болохуйц бүтээгдэхүүн, түүнийгээ нэмэгдүүлэх боломж байгаа юу? 3-т гэвэл Хөрөнгийн үнэлгээг 2 жил тутамд хийдэг, танайх энэ жил тэр хугацаа нь болж байгаа юу? ЛэндМН дээр ер нь ямар хөрөнгө байгаа вэ?

Хариулт, Гүйцэтгэх захирал Ц.Ууганбаяр: Хөрөнгийн хувьд манай нийт хөрөнгийг 98 гаруй хувьтай зээлийн багц бүрдүүлж байна. Энэ бол өөрөө зээл учраас бид олон улсын тайлагналын стандартаараа хамгийн бодит үнэ цэнээр нь тайлагнасан гэсэн үг. Өөр хөрөнгө, үл хөдлөх, эсвэл биет хөрөнгөтэй газруудын хувьд бол тэр журмаараа үнэлгээ хийлгээд явж байгаа. Манай дээр бол тэгэх шаардлага бага юм.

Шүүхийн авлагын хувьд бид 8 жилийн хугацаанд 5 сая төгрөг хүртэл үнийн дүнтэй бичил зээлийг олгож байсан. Энэ дээр зээл олгохоос өмнө бол манай кредит скор сайн ажилладаг учраас олон тооны өндөр дүнгээр шүүхийн ажиллагаа явагдах шаардлагагүй байдаг. Энэ жилээс бид бизнесийн зээл гарч байгаа учраас мэр сэр гарахыг үгүйсгэхгүй.

Хариулт, Бизнес хөгжлийн газрын захирал Ж.Сосор: 2-р асуултын хувьд бидний ашиглаж буй credit scoring гэдэг маань өөрөө харилцагчийн орлого, дансны мэдээлэл дээр үндэслээд тооцоолол хийж байгаа юм. Яг одоо манай зээлийн багц дээр харахад үндэсний үйлдвэрлэгчид олон байдаг. Бид өөрийн website-аар дамжуулаад дотоодын оёдлын үйлдвэрүүдийн харилцагчдын сэтгэгдлийг хуваалцаж байсан. Нэмээд газар тариалан, өрхийн аж ахуй эрхлэгчид бишгүй олон бий. Бид одоогийн хүрээнд бол тусгайлан үндэсний үйлдвэрлэгч гэдгийг шууд тодорхойлох боломжгүй байна. Бид цаашдаа юу бодож байна вэ гэвэл ЛэндМН өөрөө дандаа анхдагч байхыг эрмэлздэг, хэн ч орж чадахгүй буюу эрсдэлтэй гэж боддог зах зээлд орж явдаг. Ингэхээр цаашдаа гарааны бизнес эрхлэгчдийн асуудлыг ойлгоё гэж бодож байна, өөрөөр хэлбэл ямар ч зээлийн түүхгүй хүмүүс зээл авч чадахгүй байгаа тэр зах зээлийг судалж байна.

Асуулт 9: ТУЗ-ийн Хараат бус гишүүн Ж.Жаргалсүрэн та “ЛэндМН ББСБ” ХК-ийн 2024 оны үйл ажиллагааг дүгнэж, Жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг толоолон хамгаалах эрх бүхий албан тушаалтны хувьд сэтгэгдлээсээ хуваалцана уу?

Хариулт, ТУЗ-ийн Хараат бус гишүүн Ж.Жаргалсүрэн: Хараат бус 3 гишүүн өнөөдрийн хуралд бүрэн бүрэлдэхүүнээрээ оролцож байна. Би өмнө нь 4 хороодтой гэж ярьсан. Тэгэхээр энэ хороодын үйл ажиллагаанд бол хараат бус гишүүд маань идэвхтэй оролцож явлаг. Энэ хороод маань хуульд заасан заавал байлгах хараат бус гишүүдийн тоо гэж бий. Яг энэ жишгээрээ бид оролцоод явдаг. Жишээ нь Аудитын хороо заавал 2 хараат бус гишүүнтэй байх шаардлагатай. Үүнийг хангаж ажилладаг. Ер нь ТУЗ дээр тодорхой асуудлуудыг маш ил тод, нээлттэй хэлэлцдэг үүнтээ гадна гүйцэтгэх удирдлага, түүний багийн гишүүдтэй нягт хамтран ажилладаг. Ажил, төлөвлөгөөтэй нь байнга танилцаж байдаг.

2024 оны үйл ажиллагааны хувьд маш сэтгэл хангалуун байна. Ерөнхийдөө байгууллагаас өгч буй санхүүгийн тоон мэдээлэл, үйл ажиллагааны мэдээллүүд нь хэр үнэн зөв байна вэ, яригдаж буй асуудлын түвшинд хэр бэлтгэж орж байна гэдгийг байнга хянаж ажилладаг.

Мөн дотоод аудитын нэгж маань яг ТУЗ-д шууд ажлаа тайлагнах буюу Аудитын хороонд танилцуулдаг. Аудитын хороо нь дотоод аудитортой нягт ажиллаж, дотоод үйл ажиллагааг байнга мэдэж, мэдээлэл авч байдаг гэсэн үг. Үүнийгээ ТУЗ-д мэдээлэл өгөөд гүйцэтгэх удирдлага, түүний багт санал, зөвлөмж, даалгавар өгөх байдлаар ажиллаж байна. Тийм учраас удирдлагын үйл ажиллагаанд итгэлтэй байдаг.

ХЭЭХ зохион байгуулах комиссын дарга М.Түвшинжаргал:

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийн дагуу Хэлэлцэж байгаа асуудлуудтай холбогдсон асуулт, хариултын хэсэг өндөрлөлөө. Та бүхэн асууж амжаагүй асуулт байвал санал хураалтын дараагаар манай компанийн удирдлагууд, ТУЗ-ийн гишүүдээс биечилж асуух боломжтой байгаа. Одоо харин хэлэлцэж буй асуудлаар санал хураах үе шат эхэллээ.

САНАЛ ХУРААЛТЫН ХУГАЦАА 20 МИНУТ.

Одоо бүгдээрээ САНАЛ ӨГӨХ ЗААВАР-тай танилцъя.

(Хэлэлцэж байгаа асуудалд санал өгөх заавар бичлэг үзүүлэв)

ХЭЭХ зохион байгуулах комиссын дарга М.Түвшинжаргал:

ХЭЛЭЛЦЭЖ БАЙГАА АСУУДЛУУДААР САНАЛ ХУРААЖ ДУУСЛАА.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийн дагуу санал хураалтын дүнг танилцуулж, тооллогын комиссын тогтоолыг батлуулах хэсэг эхэлж байна. Индэрт тооллогын комиссын дарга С.Батбуяныг урьж байна.

Тооллогын комиссын дарга С.Батбуян:

“ЛэндМН ББСБ” ХК-ийн ХЭЭХ-ын Тооллогын комисс санал хураалтын дүнг нэгтгэж дууслаа. Тооллогын комиссын бүрэлдэхүүнд миний бие С.Батбуян, гишүүд Д.Шүрэнцэцэг, Э.Билгүүн, Х.Хулан гэсэн бүрэлдэхүүнтэйгээр ажиллалаа. Хэлэлцсэн асуудал тус бүрээр санал хураалтын дүнг танилцуулбал:

Нэг. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой дараах санал хураалтын дүнг Хувьцаа эзэмшигчдийн хурлын гишүүдэд танилцуулсугай.

1. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүнд улиран сонгогдох нэр дэвшигчид өгсөн санал хураалтын дүн:

3.1 О.Болдбаатар **603,736,179** ширхэг хувьцааны санал буюу ТУЗ-ийн ердийн гишүүдэд өгсөн нийт саналын **16.68%**;

3.2 Ц.Ууганбаяр **603,650,056** ширхэг хувьцааны санал буюу ТУЗ-ийн ердийн гишүүдэд өгсөн нийт саналын **16.68%**;

3.3 Б.Хос-Эрдэнэ **603,001,902** ширхэг хувьцааны санал буюу ТУЗ-ийн ердийн гишүүдэд өгсөн нийт саналын **16.66%**;

3.4 Кацухико Мадоно **602,797,660** ширхэг хувьцааны санал буюу ТУЗ-ийн ердийн гишүүдэд өгсөн нийт саналын **16.66%**;

3.5 Ц.Одмаа **602,946,399** ширхэг хувьцааны санал буюу ТУЗ-ийн ердийн гишүүдэд өгсөн нийт саналын **16.66%**;

3.6 С.Энх-Амгалан **602,576,284** ширхэг хувьцааны санал буюу ТУЗ-ийн ердийн гишүүдэд өгсөн нийт саналын **16.65%** байх тул Компанийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.4 дэх хэсэг, Санхүүгийн Зохицуулах хорооны “Санал хураах кумулятив аргыг хэрэглэх журам”-д заасны дагуу шийдвэр хүчинтэй.

2. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнд улиран сонгогдох нэр дэвшигчид өгсөн санал хураалтын дүн:

3.1. Ж.Жаргалсүрэн **603,299,235** ширхэг хувьцааны санал буюу ТУЗ-ийн ердийн гишүүдэд өгсөн нийт саналын **33.34%**;

3.2. С.Борбил **603,582,417** ширхэг хувьцааны санал буюу ТУЗ-ийн ердийн гишүүдэд өгсөн нийт саналын **33.36%**;

3.3. С.Нэргүй **602,472,588** ширхэг хувьцааны санал буюу ТУЗ-ийн ердийн гишүүдэд өгсөн нийт саналын **33.30%** байх тул Компанийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.4 дэх хэсэг, Санхүүгийн Зохицуулах хорооны “Санал хураах кумулятив аргыг хэрэглэх журам”-д заасны дагуу шийдвэр хүчинтэй.

3. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг батлах тухай асуудалд өгсөн нийт **71** ширхэг саналын эрх бүхий энгийн хувьцааны санал хураалтын дүн:

- 3.1 Зөвшөөрсөн **603,118,080** ширхэг хувьцааны санал буюу **100.00%**;
- 3.2 Татгалзсан **0** ширхэг хувьцааны санал буюу **0.00%**;
- 3.3 Түдгэлзсэн **0** ширхэг хувьцааны санал буюу **0.00%** байх тул Компанийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.5 дахь хэсэг, Компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.6 дахь хэсэгт тус тус заасны дагуу хуралд саналын эрхтэй оролцож байгаа хувьцаа эзэмшигчдийн олонхын саналаар шийдвэр хүчинтэй.
4. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны төсвийг батлах тухай асуудалд өгсөн нийт **71** ширхэг саналын эрх бүхий энгийн хувьцааны санал хураалтын дүн:
- 4.1. Зөвшөөрсөн **69** хувьцаа эзэмшигчийн нийт **603,065,637** ширхэг хувьцааны санал буюу **99.9913047%**
(Санал хураалтын систем нь санал хураалтын дүнг 0.00 орноор нарийвчилж тооцоолдогтой холбоотойгоор системд **99.99%** гэж харагдах бөгөөд хувь хэмжээг нарийвчлан тооцоолов);
- 4.2. Татгалзсан **1** хувьцаа эзэмшигчийн нийт **312** ширхэг хувьцааны санал буюу **0.0000517%**
(Санал хураалтын систем нь санал хураалтын дүнг 0.00 орноор нарийвчилж тооцоолдогтой холбоотойгоор системд **0.00%** гэж харагдах бөгөөд хувь хэмжээг нарийвчлан тооцоолов);
- 4.3. Түдгэлзсэн **1** хувьцаа эзэмшигчийн нийт **52,131** ширхэг хувьцааны санал буюу **0.0086436%**
(Санал хураалтын систем нь санал хураалтын дүнг 0.00 орноор нарийвчилж тооцоолдогтой холбоотойгоор системд **0.01%** гэж харагдах бөгөөд хувь хэмжээг нарийвчлан тооцоолов) байх тул Компанийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.5 дахь хэсэг, Компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.6 дахь хэсэгт тус тус заасны дагуу хуралд саналын эрхтэй оролцож байгаа хувьцаа эзэмшигчдийн олонхын саналаар шийдвэр хүчинтэй.
5. Компанийн дүрэмд оруулах нэмэлт өөрчлөлтийг батлах тухай асуудалд өгсөн нийт **71** ширхэг саналын эрх бүхий энгийн хувьцааны санал хураалтын дүн:
- 5.1. Зөвшөөрсөн **69** хувьцаа эзэмшигчийн нийт **603,117,938** ширхэг хувьцааны санал буюу **99.9999765%**
(Санал хураалтын систем нь санал хураалтын дүнг 0.00 орноор нарийвчилж тооцоолдогтой холбоотойгоор системд **99.99%** гэж харагдах бөгөөд хувь хэмжээг нарийвчлан тооцоолов);
- 5.2. Татгалзсан **1** хувьцаа эзэмшигчийн нийт **122** ширхэг хувьцааны санал буюу **0.0000202%**
(Санал хураалтын систем нь санал хураалтын дүнг 0.00 орноор нарийвчилж тооцоолдогтой холбоотойгоор системд **0.00%** гэж харагдах бөгөөд хувь хэмжээг нарийвчлан тооцоолов);
- 5.3. Түдгэлзсэн **1** хувьцаа эзэмшигчийн нийт **20** ширхэг хувьцааны санал буюу **0.0000033%**
(Санал хураалтын систем нь санал хураалтын дүнг 0.00 орноор нарийвчилж тооцоолдогтой холбоотойгоор системд **0.00%** гэж харагдах бөгөөд хувь

хэмжээг нарийвчлан тооцоолов) байх тул Компанийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.7 дахь хэсэг, Компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.5 дахь хэсэгт тус тус заасны дагуу хуралд саналын эрхтэй оролцож байгаа хувьцаа эзэмшигчдийн дийлэнх олонхын саналаар шийдвэр хүчинтэй.

Хоёр. Хэлэлцэх асуудалтай холбоотой хүчингүй болсон саналын хуудас байхгүй болохыг баталгаажуулсугай. Үүнд:

1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг батлах санал хураалтад хүчингүй болсон саналын хуудасны тоо 0 ширхэг буюу 0.00 хувийн санал;
2. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүнд улиран сонгогдох нэр дэвшигчийг сонгох санал хураалтад хүчингүй болсон саналын хуудасны тоо 0 ширхэг буюу 0.00 хувийн санал;
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнд улиран сонгогдох нэр дэвшигчийг сонгох санал хураалтад хүчингүй болсон саналын хуудасны тоо 0 ширхэг буюу 0.00 хувийн санал;
4. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны төсвийг батлах санал хураалтад хүчингүй болсон саналын хуудасны тоо 0 ширхэг буюу 0.00 хувийн санал;
5. Компанийн дүрэмд оруулах нэмэлт өөрчлөлтийг батлах санал хураалтад хүчингүй болсон санал хураалтын тоо 0 ширхэг буюу 0.00 хувийн санал;

Гурав. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд санал өгөх эрх бүхий нийт хувьцаа эзэмшигчдээс брокер, дилерийн компаниудаар дамжуулан урьдчилан ирүүлсэн 1 хувьцаа эзэмшигчийн санал байсан. Гэвч Тооллогын комиссоос шалгаж үзэхэд Компанийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.2 дахь хэсэгт заасан “тогтоосон журмын дагуу ирүүлээгүй” байх тул санал ирүүлээгүйд тооцсон гэдгийг дахинд дурдаж байна. Иймээс хурлын ирцэд тооцох санал гараагүй болохыг тэмдэглэсүгэй.

Ийнхүү тооллогын комиссын тогтоолыг гаргаж 2025 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн “ЛэндМН ББСБ” ХК-ийн ХЭЭХ-ын санал хураалтын дүнг баталгаажуулж байна.

ХЭЭХ зохион байгуулах комиссын дарга М.Түвшинжаргал:

Санал хураалтын дүнг танилцуулж, тооллогын комиссын тогтоолыг баталлаа.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийн дагуу Хурлаас гарах шийдвэрийн төсөлд Хувьцаа Эзэмшигчдийн санал хураалтын дүнг тусган, танилцуулж, батлуулах хэсэг эхэлж байна. Хэлэлцсэн асуудлуудтай холбоотой санал хураалтын дүнд үндэслэн хурлаас гарах шийдвэрийн төслүүдийг танилцуулна уу хэмээн Хурлын дарга О.Болдбаатар таныг индэрт урьж байна.

ХЭЭХ-ын дарга О.Болдбаатар:

ХЭЭХ-аас гарсан шийдвэрүүдийг уншиж танилцуулав.

(ХЭЭХ-аас гарсан шийдвэрийг хавсаргав)

ХЭЭХ зохион байгуулах комиссын дарга М.Түвшинжаргал:

Нийт хувьцаа эзэмшигчид, хөрөнгө оруулагчид, хамтран ажилладаг байгууллагууд, бүх харилцагч та бүхэндээ баярлалаа. “ЛэндМН ББСБ” ХК нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг нийт 8 дахь жилдээ амжилттай зохион байгууллаа. 2025 онд ЛэндМН-ийн хамт олон бид улам хичээн ажиллах болно.

Бидэнд үргэлж итгэл хүлээлгэж, дэмжин ажилладаг нийт харилцагчид, хамтран ажилладаг аж ахуйн нэгж, албан байгууллагууд болон хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигч та бүхэндээ хувьцаа эзэмшигчдийн хуралдаа хүрэлцэн ирсэнд талархал илэрхийлье.

Та бүхэнд ажлын амжилт хүсье. Дараа жилийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дахин уулзацгаая. Баяртай.

ТЭМДЭГЛЭЛТЭЙ ТАНИЛЦСАН:



О.БОЛДБААТАР

“ЛэндМН ББСБ” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дарга

М.ТҮВШИНЖАРГАЛ

“ЛэндМН ББСБ” ХК-ийн Санхүү, үйл ажиллагааны газрын захирал,
Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зохион байгуулах комиссын дарга

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

Б.ОЮУНБОЛД

“ЛэндМН ББСБ” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн
Нарийн бичгийн дарга